



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон АЗЗА ТӨХК-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/02/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2023 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 7035 9826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 7035 8505 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитор: Б.Байгал Утас: 99359854 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ОРХОН АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Ц.БАТЗОРИГ ТАНАА

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.15 № 87

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон АЗЗА ТӨХК-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Орхон АЗЗА ТӨХК-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын дүнгээр нийт 2,048.1 мянган төгрөгийн материаллаг зөрчил гарсан. Тайлант онд хийгдсэн 672,674.4 мянган төгрөгийн худалдан авалт нь анхан шатны баримтын бүрдэл дутуу, худалдан авах ажиллагааны хууль зөрчсөн, зарим бараа бүтээгдэхүүнийг бүртгэхдээ нийт өртгөөр бүртгэсэн зэрэг нь дүгнэлтийн үндэслэл болсон.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага тайлант онд батлагдсан орлогын төлөвлөгөөг 66,248.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, зардлыг 123,449.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, мөнгөн хөрөнгө 46,487.7 мянган төгрөгөөр буурч 1,815.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлага 242,474.2 мянган төгрөг, бараа материалын үлдэгдэл 68,570.6 мянган төгрөг, өр төлбөр 240,240.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Дээрх үзүүлэлтэд дурдагдсан авлагын үлдэгдэлд насжилт өндөртэй 162,938.1 мянган төгрөгийн авлага байгаа нь авлагаараа өглөгөө барагдуулах боломжгүйг харуулж байна.

Түүнчлэн тус байгууллагын бүртгэлд байгаа тээврийн хэрэгслүүд нь 1984-2009 оных ба элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үнэ цэнгүй 15 машинтай байгаа нь парк шинэчлэлт хийх талаар анхаарах шаардлагатай байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг шинэчлэн томилсон. Тайлант онд тус байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 3 удаа хийгдсэн бөгөөд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дотоод аудитын хороо хяналт хийж зөвлөгөө өгч ажиллаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан, аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	48,299,935.27	1,815,156.16
1.1.02	Дансны авлага	168,686,061.31	411,160,268.31
1.1.06	Бараа материал	171,904,308.41	240,474,868.87
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	1,916,448.47
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	388,890,304.99	655,366,741.81
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.01	Үндсэн хөрөнгө	643,501,251.55	620,865,548.83
1.2.02	Биет бус хөрөнгө	4,800,000.00	1,200,000.00
1.2.03	Биологийн хөрөнгө	239,110.02	239,110.02
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	648,540,361.57	622,304,658.85
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,037,430,666.56	1,277,671,400.66
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1.01	Дансны өглөг	10,454.66	120,107,954.66
2.1.1.03	Татварын өр	171,464,743.95	285,577,815.66
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	63,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	4,614,532.19
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	171,475,198.61	410,363,302.51
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	626,893,956.00	626,893,956.00
	Нийт өр төлбөр	798,369,154.61	1,037,257,258.51
2.3	Эздийн өмч	629,227,688.87	629,227,688.87
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээ	255,903,164.14	255,903,164.14
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-646,069,341.06	-644,716,710.86
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	1,352,630.20
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-646,069,341.06	-646,069,341.06
2.3.11	Эздийн өмчийн дүн	239,061,511.95	240,414,142.15
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,037,430,666.56	1,277,671,400.66

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,166,936,126.37	1,763,722,211.82
02	Борлуулалтын өртөг	994,659,403.59	1,554,270,115.28
03	Нийт ашиг(алдагдал)	172,276,722.78	209,452,096.54
08	Бусад орлого	33,384,188.27	37,786,197.92
08.1	Орлогын дүн	33,384,188.27	37,786,197.92
10	Ерөнхий ба удирдлагын зардал	203,362,250.27	245,735,372.02
12.1	Зардлын дүн	203,362,250.27	245,735,372.02
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	2,298,660.78	1,502,922.44
19	Орлогын татварын зардал	229,866.08	150,292.24
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,068,794.70	1,352,630.20
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,068,794.70	1,352,630.20
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	629,227,688.87	255,903,164.14	-646,852,354.76	238,278,498.25
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	-1,285,781.00	-1,285,781.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	2,068,794.70	2,068,794.70
09	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	629,227,688.87	255,903,164.14	-646,069,341.06	239,061,511.95
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	1,352,630.20	1,352,630.20
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
17	2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	629,227,688.87	255,903,164.14	-644,716,710.86	240,414,142.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,302,474,986.54	1,712,212,140.53
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,283,209,739.00	1,061,688,430.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,651,845.00	165,898.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	527,248,910.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	17,613,402.54	123,108,902.53
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,329,701,323.98	1,755,654,419.64
1.2.1	Ажиллагчдад төлсөн	329,292,668.77	404,630,452.27
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	106,848,705.64	110,587,274.81
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	503,078,728.00	698,505,090.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	14,811,502.04	14,950,721.10
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	301,541,256.00	444,736,201.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	35,188,297.30	9,557,718.46
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,718,659.00	17,857,500.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	36,221,507.23	54,829,462.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-27,226,337.44	-43,442,279.11
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,419,900.00	6,110,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,499,900.00	6,110,500.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,920,000.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-10,419,900.00	-6,110,500.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	4,118,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	4,118,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,169,039.00	1,050,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	3,169,039.00	1,050,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,169,039.00	3,068,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-40,815,276.44	-46,484,779.11
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	89,115,211.71	48,299,935.27
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,299,935.27	1,815,156.16

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үндсэн үзүүлэлтүүд	МЭХ ХИЖ НЭГЖ	2021 оны гүйцэтгэл	2022 он		Зөрүү	Хувь
				төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	мян.төг	1,200,320.3	1,713,571.0	1,779,819.5	(66,248.46)	103.87
	Үүнээс: Улсын чанартай АЗЗА	мян.төг	978,103.5	1,098,571.0	1,171,034.8	(72,463.76)	106.60
	Орон нутгийн чанартай	мян.төг	222,216.8	615,000.0	592,592.0	22,408.00	96.36
	Бусад орлого	мян.төг			16,192.7	(16,192.70)	
2	Нийт зардал	мян.төг	1,198,021.6	1,676,705.8	1,800,005.8	(123,300.07)	107.35
	Удирдлагын зардалд	мян.төг	225,723.0	286,120.6	273,868.9	12,251.75	95.72
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	2,298.7	36,865.2	1,502.6	35,362.66	4.08
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	2,068.8	33,178.7	1,352.3	31,826.40	4.08
5	Төсвийн төлбөр	мян.төг	254,334.4	364,066.7	236,215.7	127,851.02	64.88
	а. Орлогын татварт	мян.төг	229.9	3,324.5	150.3	3,174.24	4.52
	б. НӨАТ	мян.төг	109,120.0	155,779.2	96,369.3	59,409.88	61.86
	в. НДШ	мян.төг	117,625.5	157,219.0	125,587.3	31,631.70	79.88
	г. ХХОАТатварт	мян.төг	21,787.2	41,910.9	7,590.5	34,320.40	18.11
	д. Үл хөдлөх хөрөнгийн татварт	мян.төг	2,247.9	2,247.9	2,247.9	-	100.00
	е. Газрын төлбөр	мян.төг	1,217.2	1,217	2,028.5	(811.30)	166.65
	ё. Тээврийн хэрэгслийн татварт	мян.төг	1,188.7	1,450.0	1,453.9	(3.90)	100.27
ж. Бусад татварт	мян.төг	918.0	918.0	788.0	130.00	85.84	
6	Төрийн өмчийн ногдол ашигт	мян.төг	34.5	16,589.4	1,050.0	15,539.36	6.33
7	Ажиллагсдын тоо	хүн	37.0	43.0	39.0	4.00	90.70
8	Цалингийн сан	мян.төг	404,042.8	552,994.0	520,193.9	32,800.10	94.07
9	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	910.01	1,071.69	1,111.5	(39.83)	103.72
10	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.99	0.98	0.99	(0.01)	101.18
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	10,420.0	116,400.0	6,110.5	110,289.50	5.25
12	Нийт авлага	мян.төг	168,686.1	165,000.0	411,160.3	(246,160.30)	249.19
13	Нийт өглөг	мян.төг	798,369.1	726,893.9	1,037,257.2	(310,363.30)	142.70
	Богино хугацаат өглөг	мян.төг	100,000.0	100,000.0	410,363.3	(310,363.30)	410.36
	Урт хугацаат өглөг	мян.төг	626,893.9	626,893.9	626,893.9	-	100.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 687,876.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 2,048.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 679,601.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 6,227.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. НӨАТ-ийн баримтгүй, ирүүлээгүй 15 иргэнд 6,393.6 мянган төгрөг, 6-н аж ахуй нэгжид 3,016.6 мянган төгрөг нийт 9,410.2 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна. Үүнээс тухайн байгууллагын НӨАТ-ийн буурах дүн 301.7 мянган төгрөг, иргэнээс татварт төлөх байсан 63.9 мянган төгрөг, нийт 365.6 мянган төгрөгийн татварын зөрчил үүссэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг зөрчсөн байна.

2. Хөрөнгийн бүртгэлд нийт 23 тээврийн хэрэгсэл бүртгэсэн. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд 24 тээврийн хэрэгсэл даатгуулсан. Байгууллагын дансанд бүртгэлгүй 50-83 ОРО улсын дугаартай Истана маркийн автомашиныг жагсаалтад оруулж 95.4 мянган төгрөгийн даатгалын төлбөрийг байгууллагаас төлсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нярав, тооцооны нягтлан бодогч, ерөнхий инженер нарт ээлжийн амралтын олговор цалин хөлс, давхардуулан олгосонд 1,587.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг байгууллагын орлогоос төлсөн байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 23.1-т "Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2-т "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага

1. Тайлант онд тус байгууллага нийт 65 гэрээ байгуулснаас, 44 гэрээг үндэслэн 991,634.5 мянган төгрөгийг гүйцэтгэсэн ажлын хөлс, худалдан авсан бараа бүтээгдэхүүний үнэнд төлсөн. Байгуулсан нийт гэрээний 7 гэрээнд гэрээ дүгнэсэн акт үйлдэж, 672,674.4 мянган төгрөгийн 35 гэрээнд гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй төлбөрийг олгосон, 24 иргэнтэй байгуулсан гэрээнд техникийн тодорхойлолт хавсаргаагүй, харьцуулалт хийгээгүй шууд гэрээ байгуулж 63,318.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.2-т "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана." гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Тухайн байгууллагад бүртгэлгүй 50-83 ОРО улсын дугаартай Истана маркийн автомашинд 6,926.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д заасан "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтыг орлого болон зарлагын гүйлгээгээр ялгаж үдээгүй, гэрээг төрөлжүүлээгүй, холбогдох баримтыг бүрдүүлээгүй, 6,227.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг олгохдоо гүйцэтгэсэн ажлын тайланг хянаж баталгаажуулаагүй, И баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг эмх цэгцтэй үдэж архивлах, бараа ажил үйлчилгээнд төлөх төлбөрийг олгохдоо дахин давтагдашгүй дугаар бүхий И баримтаар баталгаажуулж байх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн бүртгэлд 80 нэр төрлийн 855,576.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ цэнгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасан заалт, НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-ийн 31 дугаар параграф "Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэний бууралтын гарзыг хассан дүн байх шаардлагатай. Дансны үнэ ба бодит үнэ цэний хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрд дахин үнэлгээг хийх шаардлагатай", 51 дүгээр параграф "Үндсэн хөрөнгийг дахин үнэлэх үед тухайн хөрөнгийн харьяалагдаж байгаа үндсэн хөрөнгийн ангийг бүхэлд нь дахин үнэлэх шаардлагатай.", "Стандартын дээрх заалтуудаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл гэсэн хөрөнгийн ангид байгаа хөрөнгүүдийн дансны үнэ нь бодит үнэ цэнээсээ материаллаг ялгаатай үед тухайн ангид байгаа бүх хөрөнгийг дахин үнэлэхийг шаардаж байна." гэсэн стандарттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үнэ цэнгүй үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, ашиглах жилийг тодорхой болгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
НӨАТ-ийн баримтгүй, ирүүлээгүй 15 иргэнд 6,393.6 мянган төгрөг, 6-н аж ахуй нэгжид 3,016.6 мянган төгрөг нийт 9,410.2 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна. Үүнээс тухайн байгууллагын НӨАТ-ийн буурах дүн 301.7 мянган төгрөг, иргэнээс татварт төлөх байсан 63.9 мянган төгрөг, нийт 365.6 мянган төгрөгийн татварын зөрчил үүссэн байна.			1	365.6									
Хөрөнгийн бүртгэлд нийт 23 тээврийн хэрэгсэл бүртгэсэн. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд 24 тээврийн хэрэгсэл даатгуулсан. Байгууллагын дансанд бүртгэлгүй 50-83 ОРО улсын дугаартай Истана маркийн автомашиныг жагсаалтад оруулж 95.4 мянган төгрөгийн даатгалын төлбөрийг байгууллагаас төлсөн байна.			1	95.4									

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нярав, тооцооны нягтлан бодогч, ерөнхий инженер нарт ээлжийн амралтын олговор цалин хөлс, давхардуулан олгосонд 1,587.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг байгууллагын орлогоос төлсөн байна.			1	1,587.1								
Тайлант онд тус байгууллага нийт 65 гэрээ байгуулснаас, 44 гэрээг үндэслэн 991,634.5 мянган төгрөгийг гүйцэтгэсэн ажлын хөлс, худалдан авсан бараа бүтээгдэхүүний үнэнд төлсөн. Байгуулсан нийт гэрээний 7 гэрээнд гэрээ дүгнэсэн акт үйлдэж, 672,674.4 мянган төгрөгийн 35 гэрээнд гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй төлбөрийг олгосон, 24 иргэнтэй байгуулсан гэрээнд техникийн тодорхойлолт хавсаргаагүй, харьцуулалт хийгээгүй шууд гэрээ байгуулж 63,318.0 мянган төгрөгийг олгосон байна.					1	672,674.4						
Тухайн байгууллагад бүртгэлгүй 50-83 ОРО улсын дугаартай Истана маркийн автомашинд 6,926.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.					1	6,926.6						
Анхан шатны баримтыг орлого болон зарлагын гүйлгээгээр ялгаж үдээгүй, гэрээг төрөлжүүлээгүй, холбогдох баримтыг бүрдүүлээгүй, 6,227.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг олгохдоо гүйцэтгэсэн ажлын тайланг хянаж баталгаажуулаагүй, И баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.							1	6,227.0				
Үндсэн хөрөнгийн бүртгэлд 80 нэр төрлийн 855,576.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ цэнгүй байна.							1					
Дүн			3	2,048.1	2	679,601.0	2	6,227.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
6	ТӨХК	1	1				1		
	НИЙТ								